



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 98

Номгон

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид хөрөнгө
шилжүүлэх талаар санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын дагуу 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ны видео хурлын зааланд “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэгийг зохион байгуулсан санал асуулгын үр дүнг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын жагсаалтад орсон Байгаль орчны газрын үндсэн ба эргэлтийн 166934.8 мянган төгрөгийн хөрөнгийг цогцолбороор нь орон нутгийн өмчид шилжүүлэх саналыг дэмжсүгэй.

2. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх тогтоолын төсөлд шинээр нэмж оруулсан нэгдүгээр хавсралтад заагдсан 5322342,9 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчөөс Орон нутгийн өмчид шилжүүлэх, саналыг уламжилсугай.

3. 2016 оны улсын үзлэг тооллогоор илэрсэн хоёрдугаар хавсралтад заагдсан давхар бүртгэлтэй 2 нэрийн 46901,3 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бүртгэлээс хасуулах саналыг уламжилсугай.

4. Дээрх хөрөнгүүдийн талаар холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, цаашид ашиглалтын талаар бодит судалгаа, зардлын тооцоо, үр өгөөж, гарах үр нөлөөг тооцож холбогдох баримт материалыг бүрдүүлэн, хөрөнгөтэй холбогдон гарсан саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

0117033

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 10-ны
өдрийн 98 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байршил	Шилжих хөрөнгө	Нийт хөрөнгийн балансын үнийн дүн
1	Номгон 1-р баг улсын бүртгэлийн чанх ард төрийн банкны салбар	<p>Хуучин төрийн банкны барилга : 292 м² талбай бүхий нэг давхар тус барилгад ОНХС-ийн хөрөнгөөр 29,5 сая төгрөгийн барилгын засварын ажил, цахилгаан монтажийн бүрэн шинэчлэлд 9,383 төгрөгийн засвар тус тус хийгдсэн. Одоогийн байдлаар 3 бүлэг 75 хүүхэдтэй, үндсэн багш-3, туслах багш-3, тогооч-1, үйлчлэгч-1, харуул-1 нийт 9 ажилчинтай цэцэрлэгийн зориулалтаар ашиглаж байгаа.</p> <p>Хөдөлмөрийн хэлтсийн хуучин барилга : ХХҮГазар нь шинэ байранд орсон ба хуучин барилгыг одоогоор хөгшчүүлийн асрамжийн газар үйл ажиллагаа явуулж байгаа үйлчлэгч-1, харуул-1, эмч-1, тогооч-1, зохион байгуулагч-1, мэдээллийн ажилтан-1, нярав-1, нябо-1 нийт 8 ажилчинтай асрамжид-11 хөгшин байгаа. Энэ барилгыг орон нутгийн өмчид шилжүүлвэл аймгийн Боловсрол соёлын газарт ашиглуулна. Учир нь тус байгууллага нь өөрийн гэсэн байргүй одоогоор МАН-ын байранд түрээсээр байрлаж байгаа. Тус газар нь үүссэн байгуулагдсанаас хойш өөрийн байргүй түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна. 2016 онд Голомт банкны байранд 6 өрөө түрээслэн сард 2800,0 мянган төгрөг төлж жилд нийт 33,600,000 төгрөгийн төлбөр төлсөн. 2017 онд аймгийн Засаг Даргын Тамгын газрын 1-р давхарт Монгол ардын намын байрны 6 өрөөг түрээслэн сард 1,400,000 төгрөгийг төлж, мөн ашиглалтын зардалаа давхар төлж байна. Нийт 24 ажилтантай, түрээсийн байранд өрөө тасалгаа хүрэлцээ муутай, нэг өрөөнд 4-6 хүн суудаг ба ажил үйлчилгээ явуулахад хүндрэлтэй байдаг. Иймд цаашид албан өрөө 9, сургалтын танхим 1, архивын өрөө (архивын баримт хадгалах), машины гражтай байр шаардлагатай байгаа тул хуучнаар Хөдөлмөрийн хэлтсийн харьяанд байсан 1 давхар байшинг Боловсрол, соёл урлагийн газрын мэдэлд шилжүүлж өгнө үү.</p>	81,297,736.22
2	Номгон 1-р баг улсын бүртгэлийн баруун талд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	<p>Одон орон судлалын харъяа Богд сум дах Чихэр өвсний станцын барилга : Одоогоор зочид буудлын зориулалттай ашиглаж байгаа. Богд сумын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй ямар байгууллагад бүртгэлтэй нь тодорхойгүй байна.</p> <p>16-16 БНХ улсын дугаартай Starex маркийн автомашин : Хуучнаар Хөдөлмөрийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 16-16 БНХ улсын дугаартай, хөдөлгүүрийн багтаамж 2476, суудлын тоо 12, 2004 онд үйлдвэрлэгдсэн, микробус суудлын зориулалттай Starex маркийн автомашиныг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэн авах саналтай байна. Учир нь манай байгууллага өмнө нь худалдан авах ажиллагааны алба, орон нутгийн өмчийн алба гээд тус тусдаа цөөхөн орон тоотой байсан тул олон суудалтай машины хэрэг гардаггүй байсан одоо 2 алба нийлээд орон тоо нэмэгдэж 11 албан хаагчтай болсон тул хөдөө гадаа томилолт, сургалтаар явахад өөрийн эзэмшлийн машин байхгүй хүндрэлтэй байдаг.</p>	181,272,000.00
3	Богд сум 6-р баг, жаргалант хорооллын-1		
4	Орон нутгийн өмчийн газрын хамгаалалтанд байгаа		16,000,000.00

4	Угалз 4 багийн төвийн барилгатай залгаа
	Дүн

Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дах Тагнуулын хэлтсийн барилга нь 1961 онд ашиглалтад орсон 43773203 төгрөгийн анхны өртөгтэй 213м² талбай бүхий 7 өрөөтэй 1 давхар барилга Г хэлбэртэй

43,773,203.00

322,342,939.22

оОо





Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 10-ны
өдрийн 98 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС ХАСАХ ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр, байршил	Давхар бүртгэлтэй хөрөнгө	Нийт хөрөнгийн балансын үнийн дүн
1	Аймгийн шүүхийн Тамгын газар Номгон баг	Аймгийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1979 онд ашиглалтад орсон 12 дугаар байрны 48,89 м ² талбай бүхий 2 өрөө орон сууцыг ашиглагч аймгийн Шүүхийн Тамгын газар үндсэн хөрөнгөд давхар бүртгэлтэй.	23,901,300.00
2	"Монгол шуудан" ТӨХК	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шуудангийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар 2013 онд бэлтгэсэн УАЗ-22069 маркийн 37-84 БНХ улсын дугаартай пургон автомашины эзэмшигчийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 113 дугаар тогтоолоор аймгийн Орон нутгийн өмчийн албыг тогтоосон байхад ашиглагч байгууллага болох "Монгол шуудан" ТӨХК нь өөрийн үндсэн хөрөнгөд давхар бүртгэлтэй.	23,000,000.00
	Дүн		46,901,300.00

_____ооо